



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 515

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаах авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Зам тээврийн хөгжлийн сайдын багц) худалдан авсан нийт 120,000,000.00 (нэг зуун хорин сая) төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу Ховд аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт бий болсон хөрөнгийг санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2 Хөрөнгийг зохих хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны... дугаар сарын...ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт



ХОВД АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Бүртгэх үнэ
					(төгрөг)
	Автобус /ZhongTong LCK6127/	2020	35 хүний суудалтай	3	120,000,000.00
Нийт дүн			120,000,000.00		
			(нэг зуун хорин сая)		